

ТАНИЛЦУУЛГА

Шүүх шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт “яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасны дагуу яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журмын төслийг боловсрууллаа.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журам” нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/217/423 дугаартай тушаалаар батлагдсан. Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан хуулийн шинэ нэр томъёо үзэл баримтлалыг журамд тусгасанаар тус журмыг хэрэглэх эрх зүйн баталгаа болох юм.

_____оОо_____